

“Дархан өргөө” ХК-ийн хувьцааг
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Дархан өргөө” ХК-ийн 714366 ширхэг хувьцааг нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар (Х.Бум-Эрдэнэ), Хөрөнгийн биржийн бүртгэлээс хасахыг “МХБ” ХК (Р.Содхүү), Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжаас хасахыг “ҮЦТТТХТ” ХХК (Т.Гандулам)-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Компаниас хувь нийлүүлэгчидтэй хийх тооцоог 2008 оны 3 дугаар улиралд багтаан дуусгаж тайланг Хороонд ирүүлэхийг “ҮЦТТТХТ” ХХК (Т.Гандулам)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын талаар Улсын бүртгэлийн албанд 10 хоногийн дотор мэдэгдэж нийтэд мэдээлэхийг Тамгын газар (Н.Удаанжаргал), тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар (Х.Бум-Эрдэнэ)-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН